



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6, 8.6.6 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 8.1.4, 11.1.1 дэх заалт, “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам”-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллын дүнг нээлттэй, ил тод болгох, иргэд, олон нийт танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /Б.Цэнгэл/-т, төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний хорооны орлогч дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН